

**“Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Мөнхбаатарын Оюу Толгойн Ханган
нийлүүлэгчдийн чуулганд хэлсэн үг**

2017 Нэгдүгээр сарын 31

Ханган нийлүүлэгчдийн чуулганд хүрэлцэн ирсэн Оюу толгой компанийн найдвартай, тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллахад хувь нэмрээ оруулан ханган нийлүүлэлт, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэн ажилласан Компанийн төлөөлөгчид, мөн шинээр өөрсдийн туршлага чадвараа хуваалцахаар ирсэн Компанийн төлөөлөгчид Та бүхэндээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

“Эрдэнэс Оюу Толгой” ХХК нь стратегийн ач холбогдол бүхий Оюу толгойн зэс-алтны ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй “Оюу толгой” ХХК-ийн төрийн эзэмшлийн 34 хувийг эзэмших эрхийг хэрэгжүүлэх, төслөөс Монголын талын хүртэх үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилготой төрийн өмчит компани.

Манай компани нь үүсгэн байгуулагдсанаасаа хойш Оюу толгой компанийн холбогдох гэрээнд заасан дотоодын ханган нийлүүлэгчдийг хөгжүүлэн дэмжихтэй холбоотой үүргийг биелүүлэхэд хувьцаа эзэмшигч талтай хамтран ажиллаж, гол зорилгоо болгон ажиллаж ирсэн.

2016 онд Гүний уурхайн бүтээн байгуулалтын ажил дахин эхэлсэн бөгөөд үүнтэй холбоотойгоор үндэсний ханган нийлүүлэгчдэд шинэ бизнесийн боломжууд нээгдэнэ гэдэгт итгэж байна.

Цаашдаа бид МУЗГ-ын бодлого, үүрэг даалгаварын хүрээнд Оюу толгой компанийн ханган нийлүүлэлттэй холбоотой дараах асуудлуудыг шат дараатайгаар шийдвэрлэхэд хувьцаа эзэмшигч талтай хамтран ажиллахаар төлөвлөж байна. Үүнд:

- Оюу толгой төсөлд урт хугацаанд (life of mine), тогтмол ашиглах бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг Монгол Улсын үндэсний компаниудаас авах, үйлдвэрлэх боломжийг судлан, хэрэгжүүлэх
- Оюу толгой төсөлтэй холбоотой ханган нийлүүлэлт, үйлчилгээ үзүүлдэг болон тендерт шалгарсан аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааг эхлүүлэх, өргөжүүлэх, хөгжих боломжийг бий болгох зорилгоор тусгай хөтөлбөрүүдийг бий болгон чадавхжуулах
- Далд уурхайн бүтээн байгуулалттай холбоотой тендерүүдийг нээлттэй хэлбэрээр зарлан, ханган нийлүүлэлтэд холбогдох ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадамжтай шинэ компаниудыг дэмжин ажиллах
- Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд тэнцсэн компанийг ил тод зарлаж, тэнцээгүй компаниудад сонгон шалгаруулалтын үнэлгээг нээлттэй ил тод тайлагнадаг байх
- Ханбогд сумыг ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжүүлэхэд хамтран ажиллах зэрэг асуудлууд багтаж байна

“Оюу толгой” ХХК-иас дотоодын ханган нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, сүлжээг өргөжүүлэх, бэхжүүлэхээр чуулганыг зохион байгуулж байгаад талархал илэрхийлье. Мөн дээрх дурдсан асуудлуудыг ажил хэрэг болгон хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

Энэхүү чуулганд оролцож өөрсдийн туршлага чадвараа хуваалцахаар ирсэн ханган нийлүүлэгч компаниудад талархал илэрхийлж чуулганы үйл ажиллагаанд амжилт хүсье.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.